

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2022 он)

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202202/01. ИНЕГ-т, Аэромонголиа ХХК. /Safety recommendation 202202/01. МСAA, Aeromongolia/.

Аэромонголиа ХХК-ийн нислэгийн үйл ажиллагаанаас үзэхэд нислэгт нөлөөлөх хязгаарлалт\limitations\-ууд тогтмол зөрчигдөж байгаа тул дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд: Нислэгт сөргөөр нөлөөлөх \Taxi exceedance in turn, Taxi speed exc. straight, Tire limit speed, High acceleration at touchdown, Overweight landing, High speed at landing, Late rotation, Questionable braking at landing болон бусад хязгаарлалт \limitations\-уудыг хянах, үр дүнг хэлэлцэж алдааг засах, нисгэх бүрэлдэхүүний үр чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн тогтолцоог бүрдүүлэх.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202202/02. ИНЕГ-т, Аэромонголиа ХХК. /Safety recommendation 202202/02. МСAA, Aeromongolia./

Аэромонголиа ХХК-ийн ЕМВ-145 агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрт резин дугуйны даралтын үзлэгийг 2 өдөр тутам Engineering order form техник үйлчилгээний хүрээнд гүйцэтгэж байгааг өөрчилж дугуй үйлдвэрлэгчийн болон SNL 145-32-0002 dated 30 April 2002 бюллетень-ийн дагуу 24 цаг тутамд дугуйны хийн даралтыг үздэг болгохоор хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202202/03. ИНЕГ-т, Аэромонголиа ХХК. /Safety recommendation 202202/03. МСAA, Aeromongolia./

Агаарын хөлгийн дугуйны даралтын үзлэгээр хэт өөрчлөлт гарсан болон давтан гарсан шалтгааныг тогтоогоогүй үзлэг үйлчилгээ хийсэн эсэх нь тодорхой бус, цаг агаарын өөрчлөлтийн нөлөөлөл даралтын хэмжилтийн үр дүн зөрөөтэй нь бодит байдал болон үйлдвэрлэгчийн заавар зөвлөмжид нийцэхгүй байсан тул дараах зөвлөмжийг өгч байна Үүнд: Дугуйны хийн даралтын өдөр тутамын үзлэгийн үр дүнгийн бодит байдалд хяналт хийдэг тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202202/04. ИНЕГ-т, Аэромонголиа ХХК. /Safety recommendation 202202/04. МСAA, Aeromongolia./

Дугуйны хийн даралт хэмжигч/tyre pressure gauge/-ийн тохиролын баталгаажуулалт болон ашиглалтыг сайжруулж загвар\этолон\ даралт хэмжигчтэй болох түүгээр хэмжигчүүдийн найдвартай ажиллагааг байнга шалгаж байх.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202202/05. ИНЕГ-т, ЧХОУНБ-д. /Safety recommendation 202202/05. МСAA, Chinggis Khaan International Airport/.

Аэродромын хөөрч буух хатуу хучилттай зурвасны бүтцэд эвдрэл гарсан тохиолдолд шалтгааныг тогтоож аюулгүй байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202202/06. ИНЕГ-т, ЧХОУНБ-д. /Safety recommendation 202202/06. МСAA Chinggis Khaan International Airport/.

Нисэх буудлын талбайд ажилладаг бүх байгууллага/агаарын хөлгийн ашиглагч, нислэгийн хоолны үйлчилгээ, цэвэрлэгээ болон бусад/-ын ажилтанд гадны биет/FOD/-ын эрсдэл түүнээс хамгаалах арга хэмжээний талаар нэгдсэн сургалтыг зохион байгуулах, сургалтын тогтолцоог бүрдүүлэх.